

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дугаар сарын 13-ний өдрийн 1/09 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн хэрэгжилтийн хяналтын систем, төслийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дагуу хүлээгдэж буй үр дүн, төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн гүйцэтгэлийг тогтмол хянаж, мэдээлэл цуглуулан анализ, дүн шинжилгээ хийх. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн Хөгжлийн түнш байгууллагуудын дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн тайлагнал хийх, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн нэгдсэн тайланг нэгтгэн гаргах. Эдийн Засаг Хөгжлийн яаманд хэрэгжиж буй бүх төслийн үйл ажиллагааны зохицуулалт, нэгдсэн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналыг нэгжийн түвшинд бүрэн хангах. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн цар хүрээнд багтах нийт төслийн санхүү, худалдан авалт, тайлан мэдээ, хэрэгжилтийн уялдааг хангах. Шинээр эхлэх төслүүдийн үйл ажиллагааг нэгдсэн нэгжийн бүтэц, зохион байгуулалттай уялдуулан хэрэгжүүлэх бодлогын хүрээг баримтлах.
2. Ажлын байрны дэд зорилтууд:	- Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг хэрэгжилтийн үе шатуудтай уялдуулан боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг тухай бүр хийх; - Төслийн үйл явцыг хянах, үнэлэх, төслийн улирал, жилийн явцын тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран боловсруулж холбогдох

	журам зааврын дагуу төслийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудыг улирал, жилээр нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах; 3. Төслийг саадгүй хэрэгжүүлэхэд нөлөөлж буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж, түүнийг арилгах арга хэмжээг Эдийн засаг, хөгжлийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Гүйцэтгэгч байгууллага болон Хөгжлийн түнш байгууллагуудад санал болгох;	
3.Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа/хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1.Төслийн зураг төсөл, хяналтын тогтолцоо болон нийгэм, жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн төслийн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог хянах, шинэчлэх, дагаж мөрдөх; 2.Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хугацаанд нь хангах; 3.Төслийн гүйцэтгэлийн хяналтын системийг цаг тухайд нь шинэчлэх; 4. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн Хөгжлийн түнш байгууллагуудын дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн тайлагнал хийх, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн нэгдсэн тайланг нэгтгэн гаргах.	Төсөл хэрэгжих хугацаанд	Холбогдох хууль, дүрэм, журам, гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлэх
5.Төслийн хэрэгжилтийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний сар, улирал, хагас жил, жилийн тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн саналын хамт бэлтгэж, холбогдох дээд шатны байгууллага, Азийн Хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Европын Хөрөнгө Оруулалтын банк болон холбогдох бусад Хөгжлийн түнш байгууллагуудад хүргүүлэх; 6.Гүйцэтгэгч байгууллага нь холбогдох гэрээний заалтуудыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, улирал, жилийн явцын тайлангаар тайлагнах; 7.Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлийн чанарыг шалгах явцад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид дэмжлэг үзүүлэх; 8.Төрийн портал системд холбогдох тайлан, мэдээллийг бэлтгэж хугацаанд нь байршуулах;	Төсөл хэрэгжих хугацаанд	Хариуцсан тайлан, мэдээг холбогдох хууль, дүрэм, журам, гэрээнд заасан хугацаанд гаргах

9. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтанд хамаарах, холбогдох хууль, дүрэм, журамд тусгагдсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;		
10.Төсөл дууссаны дараа Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бусад ажилтнуудын саналыг авч Хөгжлийн түнш байгууллагуудын шаардлагын дагуу Төслийн гүйцэтгэлийн тайланг хамтран бэлтгэх.		
11.Өгөгдлийн чанар, үнэн зөвийг шалгаж, шаардлагатай бол залруулах санал боловсруулах.	Төсөл хэрэгжих хугацаанд	Тухай бүр
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй.	
		Мэргэжил	Хөдөө аж ахуй /081/	
		Туршлага	ХАА-н төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх.	
		Ур чадвар	Англи, монгол хэлний бичгийн болон аман ярианы өндөр ур чадвартай	
	1.2.Тусгай шаардлага	Олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ), ялангуяа АХБ-ны санхүүжилттэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай.		

+Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
<u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

(И.БАТХҮҮ)

2026 оны ... дүгээр сарын ... -ны өдөр